

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 07 дүгээр сарын 02-ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Баргилт (MV-016657) төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн техник эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотгол хийх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших MV-016657 тусгай зөвшөөрөлтэй Баргилт ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотгол боловсруулах ажил болно. Баргилтын төмрийн хүдрийн ордод 2020-2021 онд ашиглалтын хайгуул хийсэн. Ордын батлагдсан нөөцөд тулгуурлан төслийн ТЭЗҮ-нд нэмэлт тодотгол хийснээр “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” УБҮ-ийн төмрийн хүдрийн үйлдвэрийн бүтээмжийг өсгөх юм.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 07 дүгээр сарын 08–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 07 дүгээр сарын 20– ны өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 302 тоот,

И-мейл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-255